

# ЕФЕС

## [1]

<sup>1</sup>Бурханы хүслээр Христ Есүсийн элч болсон Паулаас, [Ефест байгаа] болон Христ Есүс доторх итгэмжит ариун хүмүүст; <sup>2</sup>Бидний Эцэг Бурхан, Эзэн Есүс Христээс нигүүлсэл ба амар амгалан нь та нарт байх болтугай.

<sup>3</sup>Бидний Эзэн Есүс Христийн Эцэг ба Бурхан магтагдах болтугай. Тэрээр Христ дотор тэнгэрлэг газар дахь алив сүнслэг ерөөлөөр биднийг ерөөсөн.

<sup>4</sup>Түүний өмнө биднийг ариун бөгөөд гэм зэмгүй байлгахын тулд Бурхан өртөнцийн сууриас урьд биднийг Түүний дотор сонгосончлон, хайраараа

<sup>5</sup>Тэр Өөрийн хүслийн сайн тааллын дагуу, биднийг Есүс Христээр Өөрийнхөө хөвгүүд болгон үрчлэн авахаар урьдаас тогтоожээ. <sup>6</sup>Энэ нь хайрлагдсан Түүний дотор бидэнд соёрхсон Түүний нигүүлслийн алдрыг

магтуулахын тулд болой. <sup>7</sup>Түүний нигүүлслийн баялгийн дагуу Түүний дотор цусаар нь золилт, гэм нүглийн маань төлөөх уучлал бидэнд байдаг.

<sup>8</sup>Тэр бидэнд бүх мэргэн ухаан болон гүнзгий мэдлэг дотор тэрхүү нигүүлслээ бялхаажээ. <sup>9</sup>Тэр Түүний дотор зорилго тавьж, Өөрийнхөө сайн тааллын дагуу хүслийнхээ нууцыг бидэнд мэдүүлэв. <sup>10</sup>Энэ нь цагийн дүүрнийг гүйцэлдүүлэхийн тулд тэнгэр дэх юмс болон газар дээрх бүх юмсыг Христ дотор нэгтгэх зорилго байжээ. <sup>11</sup>Бүх юмсыг хүслийнхээ зөвлөгөөгөөр үйлддэг Түүний зорилгын дагуу урьдаас тогтоогдсоноор бид Түүний дотор өв залгамжлагчид болсон юм. <sup>12</sup>Ингэснээр Христэд анхлан найдсан бид Түүний алдрын магтаалын төлөө байх юм. <sup>13</sup>Түүний дотор та нар ч бас үнэний үгийг буюу та нарын авралын сайн мэдээг сонссоны дараа, мөн Түүнд итгээд, амлалтын Ариун Сүнсээр тамгалагдсан байв. <sup>14</sup>Тэр нь Бурханы эзэмшлийн золилт хүртэл бидний өвийн батлан даагч болж Түүний алдрыг магтуулахын тулд өгөгдсөн юм.

<sup>15</sup>Тиймээс би ч бас Эзэн Есүст итгэх та нарын итгэл болон бүх ариун хүмүүсийн төлөө гэсэн хайрыг чинь сонсоод, <sup>16</sup>өөрийн залбиралдаа та нарыг дурсахдаа та нарын төлөө талархал өргөдгөө болихгүй. <sup>17</sup>Ингэснээр бидний Эзэн Есүс Христийн Бурхан болох алдрын Эцэг нь Түүнийг мэдэх дүүрэн мэдлэг дотор та нарт мэргэн ухаан хийгээд илчлэлийн сүнсийг өгөх юм.

<sup>18</sup>[Та нарын] зүрхний мэлмий гийгүүлэгдэг. Тэгвэл та нар Түүний дуудлагын найдвар юу болохыг, ариун хүмүүс дотор Түүний өвийн алдрын баялаг юу болохыг, <sup>19</sup>мөн итгэдэг бидэнд хандсан Түүний хүч чадлын

хэмжээлшгүй сүр жавхлан юу болохыг мэдэх болно. Эдгээр нь Түүний хүчит чадлын үйлдлийн дагуу бөгөөд <sup>20</sup>Тэрээр Христ дотор хүч чадлаа үзүүлж, Түүнийг үхэгсдээс амилуулаад тэнгэрлэг газарт Өөрийн баруун гаралт залж, <sup>21</sup>бүх засаг захиргаа, эрх мэдэл, хүч, ноёрхол төдийгүй зөвхөн энэ үед ч биш мөн ирээдүйд нэрлэгдэх аливаа нэрээс ч эрхэм болгожээ. <sup>22</sup>Бурхан бүх юмыг Түүнд захишуулахаар хөл дор нь тавьж, Түүнийг чуулганы төлөө бүх юмын дээрх Тэргүүн болгожээ. <sup>23</sup>Чуулган нь Түүний бие буюу бүхний дотор бүгдийг Дүүргэгчийн дүүрэн байдал нь мөн.

## [2]

<sup>1</sup> Та нар өөрсдийн нүгэл, хилэнц дотор үхсэн байв. <sup>2</sup> Та нар урьд нь нүгэл, хилэнц дотор энэ ертөнцийн заншлын дагуу агаарын хүчний ноёрхогч буюу эдүгээ дуулгаваргүй хөвгүүд дотор ажиллаж буй сүнсийг дагаж явсан. <sup>3</sup> Тэдний дунд бид ч бас бүгдээрээ урьд нь маань бие болон санаа бодлын хүслүүдээ өөгшүүлэн маань биеийнхээ хүсэл тачаалууд дотор амьдарч байв. Мөн бусдын адил төрөлхөөс уур хилэнг хүртэх хүүхдүүд байсан. <sup>4</sup>Харин Бурхан өршөөлөөр баян ажээ. Тэр биднийг хайлласан Өөрийн агуу хайраараа <sup>5</sup>биднийг гэм нүгэл дотроо үхсэн байхад Христтэй хамт амьд болгосон юм. Та нар нигүүлслээр аврагдсан билээ. <sup>6</sup>Биднийг Түүнтэй хамт амилуулж, тэнгэрлэг газарт Христ Есүс дотор Түүнтэй хамт суулгасан <sup>7</sup> нь Христ Есүс дотор бидэнд хандсан энэрлээр Өөрийн нигүүлслийн хэмжээлшгүй баялгийг ирэх үеүдэд үзүүлэхийн тулд юм. <sup>8</sup>Учир нь нигүүлслээр та нар итгэлээрээ аврагдсан юм. Энэ нь та нараас биш харин Бурханы бэлэг бөгөөд <sup>9</sup>үйлсээр биш аж. Тиймээс хэн ч өөрөөрөө сайрхахгүй болно. <sup>10</sup>Учир нь бид сайн үйлсийн төлөө Христ Есүс дотор бүтээгдсэн, Түүний бүтээл мөн. Бурхан биднийг тэдгээрийн дотор яваасай гэж урьдаас бэлтгэсэн билээ.

<sup>11</sup> Тиймд санагтун. Та нар урьд маань биеэрээ Харь үндэстэн байхдаа, маань биедээ хүний гараар "Хөвч хөндүүлсэн" гэж нэрлэгдэгсдээр "Хөвч хөндүүлээгүй" гэж нэрлэгдэж байв. <sup>12</sup>Тэр үед та нар Христээс тусгаарлагдсан байв. Та нар Израилийн нийгмээс гадна, амлалтын гэрээнүүдийн хувьд харь хүмүүс байв. Та нар ямар ч найдваргүй, ертөнцөд Бурхангүй байлаа. <sup>13</sup>Харин урьд нь алс хол байсан та нар эдүгээ Христ Есүс дотор Христийн цусаар ойр болов.

<sup>14</sup> Учир нь Тэр Өөрөө бидний энх тайван мөн. Тэр хоёр хэсгийг нэг болгож, хуваагдлын ханыг ба дайсагналыг Өөрийн маань бие дотор устгав. <sup>15</sup>Тэр Өөрийнхөө дотор мөнөөх хоёрыг нэг шинэ хүн болгохын тулд зарлиг

доторх тушаалуудын Хуулийг хүчингүй болгожээ. Ингэж энх тайвныг тогтоогоод, <sup>16</sup>тэднийг аль алийг нь нэг бие дотор загалмайгаар дамжуулан Бурхантай эвлэрэх боломжтой болгов. Үүгээр дайсагналыг хөнөөв. <sup>17</sup>Тэр ирж, алс хол байсан та нарт болон ойр байгсдад энх тайвныг тунхагласан юм. <sup>18</sup>Тиймээс бид цөмөөрөө нэг Сүнс дотор Христээр дамжуулан Эцэг уруу очих замтай болжээ. <sup>19</sup>Тийм бол та нар цаашид харь хүмүүс болон гадны хүмүүс биш, харин ариун хүмүүсийн адил нутгийн иргэд бөгөөд Бурханы гэр бүлийнх юм. <sup>20</sup>Та нар элч нар болон эш үзүүлэгчдийн суурин дээр босгогдож байгаа бөгөөд Христ Есүс Өөрөө булангийн Чулуу нь ажээ. <sup>21</sup>Түүний дотор бүх барилга хамтдаа нийцэн Эзэн доторх ариун сүм болохоор өсөж байна. <sup>22</sup>Та нар ч гэсэн Сүнс дотор Бурханы орших газар болохоор Христ дотор хамтдаа байгуулагдаж байна.

### [3]

<sup>1</sup>Үүний улмаас Паул би бол Харь үндэстнүүд болох та нарын төлөөх Христ [Есүсийн] хоригдол мөн. <sup>2</sup>Та нарын төлөө надад өгөгдсөн Бурханы нигүүлслийн нярвын үүргийн талаар та нар сонссон. <sup>3</sup>Би урьд нь товчон бичсэнчлэн тэрхүү нууц нь надад илчлэлтээр мэдэгдсэн юм. <sup>4</sup>Та нар түүнийг уншаад, Христийн нууцын талаар миний ойлголтыг мэдэж чадна. <sup>5</sup>Энэ нь өөр үеийнхэнд, хүний хөвгүүдэд мэдэгдээгүй боловч эдүгээ Сүнс дотор Түүний ариун элч нар ба эш үзүүлэгчдэд илчлэгдсэнээр <sup>6</sup>Харь үндэстнүүд энэхүү биеийн хамтран өв залгамжлагчид ба эрхтнүүд болох бөгөөд сайн мэдээгээр дамжуулан Христ Есүс дотор амлалтыг хамтран хуваалцагчид болжээ. <sup>7</sup>Бурхан хүчний үйлчлэлээрээ надад өгсөн Түүний нигүүлслийн бэлгийн дагуу би сайн мэдээний үйлчлэгч болсон. <sup>8</sup>Бүх ариун хүмүүсээс хамгийн өчүүхэн нь болох надад энэхүү нигүүлсэл өгөгдсөний учир нь Христийн нэвтэршгүй баялгийг Харь үндэстэнд тунхаглаж, <sup>9</sup>бүх юмыг бүтээсэн Бурханы дотор үеэс үед нууцлагдаж байсан нууцын үйлчлэлийн үүрэг нь юу болохыг [бүгдэд] мэдүүлэхийн тулд байлаа. <sup>10</sup>Ингэснээр эдүгээ чуулганаар дамжуулан Бурханы олон янзын мэргэн ухаан тэнгэрлэг газар дахь захирагчид болон эрх мэдэлтнүүдэд мэдэгдэх юм. <sup>11</sup>Бидний Эзэн Христ Есүсийн дотор үйлдсэн мөнхийн зорилгын дагуу Тэр ингэсэн ажээ. <sup>12</sup>Бид Христэд итгэх итгэлээрээ дамжуулж Түүнд зоримог байдал ба бат итгэлтэйгээр очиж болно. <sup>13</sup>Тиймээс би та нараас гүйя. Та нарын төлөөх миний зовлон шаналлаас болж бүү зүрх алдаарай. Эдгээр нь та нарын алдар билээ.

**14** Иймд би Эцэгийн өмнө өвдөг сөгдөж, **15** тэнгэр болон газар дахь бүхэл гэр бүлийг нэрлэдэг Түүнд залбирч байна. **16** Тэр Өөрийн алдрын баялгийн дагуу Өөрийн Сүнсээр дамжуулан хүч чадлаар та нарын доторх хүнийг хүчтэй болгон соёрох болтугай. **17** Ингэж итгэлээр Христ та нарын зүрхэнд нутаглаж, та нар хайр дотор үндэслэж суурилаад, **18** бүх ариун хүмүүсийн хамт тэр хайрын ямар өргөн, урт, өндөр хийгээд гүн болохыг ойлгох болтугай. **19** Мэдлэгийг давдаг Христийн хайрыг мэдсэнээр та нар Бурханы бүх дүүрэнд хүртэл бялхсан байх болтугай.

**20** Эдүгээ, бидний дотор ажилладаг хүчний дагуу гүйж, бодох бүхнээс минь илүү хэмжээлшгүй бялхлаар үйлдэх чадвартай Түүнд **21** алдар нь чуулган дотор, Христ Есүс дотор бүх үеийнхэнд үеийн үед байх болтугай. Амен.

## [4]

**1** Иймд та нар дуудагдсан тэрхүү дуудлагадаа зүй зохистой явахыг Эзэний хоригдол би хичээнгүйлэн ятгая. **2** Ингэхдээ аливаа төлөв даруу байдлаар бөгөөд дөлгөөн сэтгэлээр хайр дотор бие биенийгээ хүлцэн тэвчиж, **3** амар тайвны хүлээс дотор Сүнсний нэгдлийг хадгалахыг хичээгтүн. **4** Та нар өөрсдийнхөө дуудлагын нэг найдвар дотор дуудагдсаны адил нэг бие, нэг Сүнс, **5** нэг Эзэн, нэг итгэл, нэг баптист, **6** нэг Бурхан байна. Тэр бол бүгдийн Эцэг бөгөөд бүгдийн дээр бүгдээр дамжуулан бүгдийн дотор байдаг.

**7** Харин Христийн бэлгийн хэмжээгээр бидний хүн нэг бүрд нигүүлсэл өгөгдсөн байв. **8** Тиймээс

"Өндөрт дээш гарахдаа,  
Тэр олон хоригдол олзлов.  
Тэр хүмүүст бэлгүүд өгсөн" гэж хэлдэг.

**9** "Тэр дээш гарсан" гэдэг нь Тэр бас газрын доод хэсэгт буусан гэдгээс өөр ямар утгатай вэ? **10** Доош буусан Тэр нь бүх юмыг дүүргэхийн тулд бүх тэнгэрүүдийн дээр дээш гарсан Тэр Өөрөө мөн юм. **11** Тэр заримыг нь элч, заримыг нь эш үзүүлэгч, заримыг нь сайн мэдээг тунхаглагч, заримыг нь хоньчин ба багш болгожээ. **12** Эдгээр нь ариун хүмүүсийг үйлчлэлийн ажилд бэлтгэж, Христийн биеийг байгуулахын тулд юм. **13** Бид бүгд итгэл хийгээд Бурханы Хүүг мэдэх мэдлэгийн нэгдэл хүртэл, төлөвшөн хүн болтол, Христийн дүүрэн байдлын чанарын хэмжээнд хүртэл ингэх ажээ. **14** Үүний үр дүнд бид цаашид хүүхэд байхаа больж, давалгаанд энд тэнд шидэгдэн,

аливаа номлолын салхи, хүмүүсийн ов мэх болон зальхай хуйвалдааны башир арганд туугдалгүй, <sup>15</sup>харин хайр дотор үнэнийг ярин, бид тэргүүн болох Түүн уруу, Христ уруу бүх талаар өсөх ёстай. <sup>16</sup>Хэсэг нэг бүрийн зохистой үйл ажиллагааны дагуу холбоос бүрийн хангаж байдаг зүйлээр хамтдаа холбогдон нийлж буй бүхэл бие нь Христээр хайр дотор өөрийгөө босгон барихын тулд биеийн өсөлтийг бий болгодог.

<sup>17</sup>Тиймээс би Эзэний дотор үүнийг хэлж, гэрчилье. Харь үндэстнүүд оюун санааны хоосрол дотроо явдаг шиг та нар цаашид тэгж явж болохгүй. <sup>18</sup>Тэд өөрсдийнхөө дотор буй харанхуй байдлаас, зүрхнийхээ хатуугаас болж оюун ухаандаа харанхуй болж, Бурханы аминаас хөндийрчээ. <sup>19</sup>Тэд мэдрэмжгүй болж, зүсэн бүрийн бузар булаг шунахайран үйлдэхийн тулд тачаангуй байдалд өөрсдийгөө тушаажээ. <sup>20</sup>Харин та нар ийм замаар Христийг сураагүй. <sup>21</sup>Есүс дотор үнэн байгаачлан, та нар үнэхээр Түүнийг сонсож, Түүгээр сургагдсан юм бол, <sup>22</sup>чиний амьдралын урьдын хэв маягт хамаарах заль мэхийн тачаалын дагуу ялзарч буй хуучин хүнээ та нар хойш тавьж, <sup>23</sup>оюун санааныхаа сүнс дотор шинэчлэгдэж, <sup>24</sup>зөвт байдал болон үнэний ариун байдал дотор Бурханы дагуу бүтээгдсэн шинэ хүнийг өөртөө өмс.

<sup>25</sup>Тиймд худал хуурмагийг хойш тавьж, хүн нэг бүр хөршдөө үнэнийг ярь. Учир нь бид бие биенийхээ эрхтнүүд юм. <sup>26</sup>Уурласан ч, нүгэл бүү үйлд. Та нарын уур хилэн дээр нар бүү жаргаг. <sup>27</sup>Диаволд байр бүү өг. <sup>28</sup>Хулгайч хүн цаашид хулгай бүү хий. Харин ч гачигдалтай хүнд хуваалцах юмтай байхын тулд [өөрийн] гараар сайныг үйлдэж, хөдөлмөрлө. <sup>29</sup>Та нарын амнаас ямар ч ялзарсан үг бүү гараг. Харин хэрэгтэй үед нь бусдыг босгон байгуулахын тулд зөвхөн тустай үг хэл. Тэгвэл энэ нь сонсож буй хүнд нигүүлслийг өгнө. <sup>30</sup>Бурханы Ариун Сүнсийг бүү гомдоо. Золилтын өдрийн төлөө та нар Түүгээр тамгалуулсан билээ. <sup>31</sup>Аливаа хорсол, уур, хилэн, шуугиан, гүтгэлэг нь бүх бузар муугийн хамт та нараас зайлаг. <sup>32</sup>Бурхан та нарыг Христ дотор училсны адил бие биенээ учлан, нэг нэгнийгээ энэрэн уян зөөлөн сэтгэлээр ханд.

## [5]

<sup>1</sup>Тиймээс хайрлагдсан хүүхдүүд адил Бурханыг дуурайгчид болцгоо.  
<sup>2</sup>Христ та нарыг хайрласан бөгөөд Өөрийгөө бидний төлөө Бурханд анхилуун үнэрт өргөл ба тахил болгон өргөсний адил хайр дотор яв. <sup>3</sup>Харин ариун хүмүүст үл нийцэх садар самуун, аливаа бузар булаг, шунал нь та

нарын дунд бүг дурсагдаг. <sup>4</sup>Бузар булаг болон мунхаг яриа, эсвэл тоглоом тохуу нь зохимжгүй. Харин оронд нь талархлаа өргө. <sup>5</sup>Садар самуун, бузар булаг үйлдэгч, шүтээнийг шүтэгч шунахай ямар ч хүнд Христийн болон Бурханы хаанчлалд өв байхгүй гэдгийг та нар ойлго.

<sup>6</sup>Хэн ч та нарыг хоосон үгсээрээ бүг мэхлэг. Яагаад гэвэл эдгээрээс болж Бурханы уур хилэн дуулгаваргүй хөвгүүд дээр буудаг юм. <sup>7</sup>Иймд тэдний хамсаатан байж болохгүй. <sup>8</sup>Учир нь та нар урьд нь харанхуй байсан. Харин одоо та нар Эзэн дотор гэрэл ажээ. Гэрлийн хүүхдүүд шиг яв. <sup>9</sup>Учир нь алив сайн, зөвт байдал ба үнэн дотор гэрлийн үр жимс байна. <sup>10</sup>Ингэхдээ Эзэнд таалагдах юманд суралц. <sup>11</sup>Харанхуйн үр жимсгүй ажлуудад бүг оролц, харин ч тэдгээрийг илчлэгтүн. <sup>12</sup>Учир нь тэдний нууцаар үйлдсэн зүйлсийг ярихад ч ичмээр юм. <sup>13</sup>Харин бүх зүйлс гэрлээр илчлэгдэхдээ харагддаг. <sup>14</sup>Учир нь харагддаг аливаа зүйл нь гэрэл юм. Тиймд

"Нойрсогч оо, сэр.

Үхэгсдээс бос.

Христ чиний дээр гэрэлтэх болно"

гэдэг.

<sup>15</sup>Тиймээс та нар мэргэн бус хүмүүс шиг биш, харин мэргэн хүмүүсийн адилаар хэрхэн алхаж буйгаа хянаж бай. <sup>16</sup>Цагийг авар. Яагаад гэвэл өдрүүд нь бузар булаг аж. <sup>17</sup>Тийм учраас бүг мунхаг бай. Харин Эзэний хүсэл юу болохыг ухаар. <sup>18</sup>Дарсанд бүг согтуур. Ингэвэл дураараа дургих байдалд автагдана. Харин Сүнсээр дүүрэн байж, <sup>19</sup>дуулал, магтуу ба сүнслэг дуунуудаар нэг нэгэнтэйгээ ярилцаж, Эзэнд хандаж зүрхэндээ дуулж, ая дуу зохиогтун. <sup>20</sup>Бурхан болон Эцэгт бүхний төлөө бидний Эзэн Есүс Христийн нэрээр үргэлж талархал өргө. <sup>21</sup>Христээс эмээн нэг нэгэндээ захирагд.

<sup>22</sup>Эхнэрүүд ээ, Эзэнд захирагддаг шиг нөхрүүддээ захирагд. <sup>23</sup>Учир нь Христ чуулганы толгой байдгийн адил нөхөр нь эхнэрийнхээ толгой юм. Христ Өөрөө тэр биеийн Аврагч мөн. <sup>24</sup>Чуулган Христэд захирагддагийн адил түүнчлэн эхнэрүүд нөхрүүддээ бүх талаар захирагд. <sup>25</sup>Нөхрүүд ээ, Христ чуулганыг хайлраад түүний төлөө Өөрийгөө өгсний адил эхнэрүүдээ хайлра. <sup>26</sup>Тэр чуулганыг үгээр дамжуулан усанд угааж цэвэрлэн, ариусгаад <sup>27</sup>түүнийг ямар ч толбогүй, ямар ч үрчлээсгүй бөгөөд тиймэрхүү ямар ч зүйлгүй, харин ариун, гэм зэмгүй байлган Өөрийнхөө өмнө алдарт чуулган болгох гэсэн ажээ. <sup>28</sup>Тиймээс нөхрүүд ч эхнэрүүдээ өөрийн бие адил хайлрах ёстой. Эхнэрээ хайлладаг хүн өөрийгөө хайлладаг. <sup>29</sup>Учир нь хэн ч

хэзээ ч өөрийн махан биеийг үзэн ядаж байгаагүй. Харин тэжээж, хамгаалдаг. Христ мөн чуулганд ийнхүү ханддаг. <sup>30</sup> Яагаад гэвэл бид Түүний биеийн эрхтнүүд юм. <sup>31</sup>"Тиймээс эр хүн эцэг эхээ орхиж, эхнэртэйгээ нийлдэг. Тэр хоёр нэг махан бие болно". <sup>32</sup>Энэ нууц бол агуу билээ. Гэвч би Христ болон чуулганы тухай хэлж байна. <sup>33</sup>Та нарын нэг бүр чинь өөрийгөө хайлрадгийн адил эхнэрээ хайлра. Эхнэр нь нөхрөөсөө эмээж бай.

## [6]

<sup>1</sup>Хүүхдүүд ээ, [Эзэн дотор] эцэг эхээ дага. Учир нь энэ бол зөв юм. <sup>2</sup>"Эцэг эхээ хүндэл". Энэ нь амлалт бүхий эхний тушаал бөгөөд <sup>3</sup>"Энэ нь чамд сайн бөгөөд чи дэлхий дээр урт наслах болно" гэжээ. <sup>4</sup>Эцгүүд ээ, та нар хүүхдүүдээ бүү уурлуул. Харин тэднийг Эзэний дэг журам болон сургамж дотор хүмүүжүүл.

<sup>5</sup>Боолчууд аа, Христийг дагадгийн адил та нар эмээхүй болон чичрэлтээр чин сэтгэлээсээ махан биеийн дагуу эздэд дуулгавартай бай. <sup>6</sup>Хүмүүст нийцүүлэгчдийн адил харцаар үйлчлэлгүй, харин Христийн боолууд адил Бурханы хүслийг зүрх сэтгэлээсээ үйлд. <sup>7</sup>Хүмүүст биш, харин Эзэнд мэт сайн хүслээр үйлчил. <sup>8</sup>Боол, эсвэл чөлөөт байх нь ялгаагүй аливаа хүн ямар нэг сайн зүйл хийвэл тэр хүн Эзэнээс түүнийгээ буцааж авна гэдгээ мэдэн үйлчил. <sup>9</sup>Эзэд ээ, үүний адил боолууддаа ханд. Тэдний болон та нарын Эзэн тэнгэрт байгааг болон Түүний ялгаварладаггүй болохыг ойлгон, айлгаж сүрдүүлэхээ боль.

<sup>10</sup>Эцэст нь Эзэн дотор ба Түүний чадлын агуу хүч дотор бэхжигтүн. <sup>11</sup>Та нар диаволын заль мэхийн эсрэг бат зогсох чадвартай байхын тулд Бурханы бүрэн хуяг дуулгыг өмс. <sup>12</sup>Учир нь бидний тэмцэл бол махан бие ба цусны эсрэг биш, харин захирагчид, эрх мэдэл, энэхүү харанхуй ертөнцийн хүчинүүд, тэнгэрлэг газар дахь бузар муугийн сүнслэг хүчний эсрэг билээ. <sup>13</sup>Тиймээс бүхнийг хийсний дараа, бузар муу өдөрт эсэргүүцэн бат зогсох чадвартай байхын тулд Бурханы бүрэн зэвсгийг ав. <sup>14</sup>Тэгээд бат зогс. Ингэхдээ та нар бэлхүүсээрээ үнэнийг бүсэлж, зөвт байдлын хуягийг өмсөөд, <sup>15</sup>amar тайвны сайн мэдээний бэлэн байдлыг хөлдөө өмс. <sup>16</sup>Энэ бүгд дээр муу нэгний бүх галт сумыг унтрааж чадах итгэлийн бамбай, <sup>17</sup>авралын дуулгыг болон Сүнсний сэлэм буюу Бурханы үгийг ав. <sup>18</sup>Сүнс дотор цаг үргэлж аливаа залбирал ба гүйлтаараа залбир. Үүний тулд бүх ариун хүмүүсийн төлөөх цөхрөлтгүй бүх оролдлого, гүйлтаараа сэргэг бай.

**19** Сайн мэдээний нууцыг зоригтойгоор мэдүүлэхээр миний ам ангайхад үг өгөгдөхийн тулд миний төлөө залбир. **20** Үнийг хэрхэн зоригтойгоор ярих ёстой, тэгж ярихын тулд би сайн мэдээний төлөө элчин сайд болов.

**21** Та нарт бас миний байдлын тухай болон юу хийж байгааг минь мэдүүлэхийн тулд Эзэн дотор итгэлт үйлчлэгч хайрт дүү Тухик та нарт бүгдийг мэдэгдэх болно. **22** Тэр та нарт бидний байдлыг мэдүүлэн та нарын зүрхийг тайвшруулаг хэмээн, энэ зорилгоор би түүнийг илгээлээ.

**23** Эцэг Бурхан ба Эзэн Есүс Христээс амар амгалан болон хайр нь итгэлийн хамт ах дүү нарт байг. **24** Бидний Эзэн Есүс Христийг ялзаршгүй хайраар хайрлагч бүх хүмүүст нигүүлсэл байх болтугай.